



1983-6 - 2

УЛААНБААТАР хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

Дугаар 119

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. "Улаанбаатар хотын улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын орон сууцны" байрны олон нийтийн зөвлөл"-ийн дүрмийг баталсугай. /Дүрмийг хавсаргав./

2. Энэ дүрэм гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1969 оны 123 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотын улс хоршоолол, олон нийтийн байгууллагын орон сууцны "байрны олон нийтийн зөвлөлийн дүрмийг" хүчингүй болгосугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

МАРГА *[Signature]* С.МЭНХЖАРГАЛ

ХАМГУУЦЛАГАТАЙ НАРСЫН БИЧИЙН
МАРГА *[Signature]* Ч.ЖАМБАЛ



Урлын дааниаатар хотны АДХ-ын гүйцэтгэх гүйцэтгэх хурлааны 1983 оны 6 дугаар сарын 119 дугаар тогтоолоор батлав.

УЛААНБААТАР УРСЫН УИС, ХОРШООЛОЛ, ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОН СУУЦНЫ БАЙРЫН ОЛОН НИЙТИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

НЭГ. Ерөнхий зүйл.

1. Байрын олон нийтийн зөвлөл /БОНЗ/ тухайн сууцны барилгад оршин суугч нэг бүрээр орон сууцны ашиглалтын дүрэм, орчны тохижилт, ариун цэврийг ямагт хэвийн байлгахад суугчдыг зохион байгуулах үүрэгтэй олон нийтийн байгууллага юм.

БОНЗ нь орон сууц ашиглалтын байгууллагын дэргэдэх төлөөлөгчдийн зөвлөл, ОСА-ын байгууллагын удирдлага шийдвэрийг хэлбэрэлтгүй биелүүнэ.

2. Байрын олон нийтийн зөвлөлийг айл ерхийн тоог харгалзан, районы АДХ-ын гүйцэтгэх захиргаатай хамтран ОСА-ын байгууллагаас хариуцан орчны ажлагч, ариун цэвэр, тохижилт соёл олон түмний комисс, биеийн тамир, уран сайхны зөвлөлийн бүрэлдэхүүнтэйгээр суугчдын хурлаас 2 жилийн хугацаагаар байгуулж Зөвлөлийн даргыг сонгоно.

3. Байрын олон нийтийн зөвлөл нь ажлаа сараар төлөвлөн суугчдын хурлаар баталж, ажиллахын хамт жилд I-ээс доошгүй удаа суугчдад тайлангаа тавина.

ХОЁР. Байрын олон нийтийн зөвлөлийн үүрэг

4. БОНЗ нь суугчдын хүчийг зохион байгуулан хариуцсан байшин, түүний орц, коридор, шат, хүүхдийн тоглоом, зүлэгжүүлсэн болон бусад талбай, гадна орчныг тогтмол цэвэр байлгаж, хаалга, цонх, орц, коридорын гэрэл, хог дамжуулах суваг, бусад тоног төхөөрөмж, нийтийн эзэмшлийн эд аж ахуйг бүрэн бүтэн байлгана.

5. Суугчдыг амралт, баяр ёслолын өмнөх өдөр, ажлын бус цагаар байрын ашиглалт, эзэмшилтэй холбогдсон хурал, цуглаан, ухуулга таниулга болон байшин хорооллын тохижилт, цэвэрлэгээ эргүүл, жижүүрт зохион байгуулж оролцуулна.

6. Суугчдын болон байшингийн ашиглалт эзэмшилтэй холбогдсон бүртгэл судалгааг нарийн хөтөлж, дулаан ус, гэрлийн зарцуулалт, сууцны хөлс төлөлтөнд хяналт тавьж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулна.

7. Улс хоршоолол, олон нийтийн байгууллагын орон сууц ашиглах дүрмийн заалтыг /хамаарагдах/ зөрчил зохисгүй байдал гаргагчдыг тухай бүр илрүүлэн зохиох байгууллагад мэдэгдэж арга хэмжээ авахуулж байна.

8. Байшингийн орчин, орд, подвалд хэрэг зөрчил, гал түймэр, хөддөлт гарахаас урьдчилан сэргийлэх, нийтийн эзэмшлийн эд аж ахуйг нүдлэн хамгаалах, эргүүл жижүүрийг ОСГ-ны хороотой хамтран суугчдын дотроос зохион байгуулж, тогтмол ажиллуулна.

9. Байшингийн ашиглалтанд хийгдэх хавар, намрын үзлэгт оролцон илэрсэн зөрчлийг засуулж, их, урсгал засварын явц, чанарт хяналт тавьж, өвлийн бэлтгэл хангах, хүлээн авахад оролцоно.

10. Суугчдад аятай нөхцөлийг бүрдүүлэхэд байнга анхаарал тавьж гэр ахуйн болон засварын нөхөрлөл байгуулах зэрэг суугчдын идэвх санаачилгыг дэмжиж тэднээс тавьсан асуудлыг шийдвэрлэж өгнө.

ГУРАВ. Байрн олон нийтийн зөвлөлийн эрх

11. Оршин суугчдаас, байрн ашиглалт эзэмшилтэй холбогдсон асуудлаар эрэлт, хүсэлтийг хүлээн авч, орон сууц ашиглалтын болон бусад холбогдох байгууллагад тавьж зохиох арга хэмжээ авахуулах.

12. Орон сууц, түүний тоног төхөөрөмж, эд аж ахуйг зөв эзэмшиж ашиглах шаардлагыг суугчдад тавина.

Авхгз-нм 1484 өм 161 д тэглэ

13. БОНЗ-ийн сонгуульд ажлыг сайн гүйцэтгэж байгаа идэвхтэн, сууцна үлгэр жишээ эзэмшдэг суугчдыг шагнал урамшилд тодорхойлж, ОСА-ын байгууллагын үйлчилгээний ажилчдын ажилд үнэлэлт өгч, харуцсан үүргээ сайн биелүүлдсэн нөхцөлд БОНЗ-ийн дарга нь сар бүр байрн хөлснөөс 50 төгрөгийн хөлс хөнгөлүүнэ.

14. Улс хоршоолол, олон нийтийн байгууллагын орон сууц ашиглалтын дүрэм зөрчигчид болон зөвлөлөөс зохиосон ажилд хангалтгүй оролцдог хүмүүсийг зөвлөлийн хурлаар хэлэлцэж, олон нийтийн арга хэмжээ авахын хамт, шаардлага тэй гэж үзвэл, зөвлөлийн санал тодорхойлолтыг ажиллаж байгаа албан байгууллага, ОСГ-ны хороо, олон нийтийн шүүх зэрэг зохиох байгууллагад тавьж биелэлтийг шаардана.

15. Байр солих бусдад шилжүүлэхэд санал өгнө.

ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА